Коронавируст халдвар (COVID-19)-ын үед дурангийн тасгийн ажиллах түр заавар

Х.Оюнцэцэг[1,2], Р.Намсрай[1,2], М.Бадрах[1,2,3], О.Баярсайхан[1,2,3], Б.Гантуяа[1,2,3], Д.Даваадорж[1,2,3], А.Энх-Амар[1,2,3], Д.Соёлмаа[1,2], Ч.Баярнэмэх[1,2]

[1]АШУҮИС-ийн Монгол Япон сургалтын эмнэлгийн Дурангийн тасаг
[2]Монголын Ходоод Гэдэсний Дурангийн Эмч Мэргэжилтнүүдийн Нийгэмлэг
[3]АШУҮИС. АУС-ийн ХБЭС-ын Тэнхим
oyuntsetseg.kh@mnums.edu.mn

Товч хураангуй:

COVID-19 цар тахлын үед дурангийн тасагт баримтлах түр зааварчилгаа нь дурангаар дамжуулан халдвар тархах эрсдэлээс урьдчилан сэргийлэх, дурангийн тусламж үйлчилгээний аюулгүй байдлыг хангах, ажилчдыг халдвараас сэргийлэх мэдлэг олгохоор нийт гастроэнтеролог, дурангийн эмч, сувилагч, ариутгагч, мэргэшил олгох дамжааны суралцагсдад зориулагдсан. Энэхүү удирдамжийг АШУҮИС-ийн Монгол Япон эмнэлгийн дурангийн тасгийн эмч, сувилагч нар; АШУҮИС, АУС-ийн ХБЭС-ын Тэнхмийн багш нар, Монголын Ходоод Гэдэсний Дурангийн Эмч Мэргэжилтнүүдийн Нийгэмлэгээс боловсруулан гаргалаа.

ЗААВРЫГ ХЭРЭГЛЭГЧИД:

Гастроэнтеролог, Дурангийн эмч, сувилагч, ариутгагч, мэргэшил олгох дамжааны суралцагсад.

ҮНДСЭН ЗӨВЛӨМЖ:

Коронавирусээс үүдэлтэй амьсгалын цочмог дутагдлын үед эмнэлгийн дурангийн тасаг нь агаар дусал, өтгөн мөрийн байдал, дурангаар дамжуулан халдварыг тараах эрсдэлтэй. Иймд уг цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор эмнэлгийн тусламж үйлчилгээний явцад дурангийн тасагт баримтлах аюулгүй ажиллагааны журмыг боловсруулан мөрдөж ажиллах шаардлагатай.

Эмнэлэгүүдийн дурангийн тасагт баримтлах журмыг COVID-19 цар тахлын халдвар тархалтын нөхцөл байдалтай уялдуулан тухайн бүс нутагт тохирох заавар боловсруулан мөрдөж ажиллахыг Дэлхийн Дурангийн Байгууллага (WEO) зөвлөж байна.

Хамар залгиурын шинжилгээнд COVID-19 илрээгүйч өтгөний шинжилгээнд вирус 28 хоногийн хугацаанд илэрч байгаагаас гадна COVID-19 халдвар бүхий, шинж тэмдгийн илрэлгүй хүмүүс нь халдварын үндсэн уурхай, халдвар тээгчид байж болохыг үгүйсгэхгүй байна.

Монгол улсад батлагдсан 15 хүнд хийсэн эмнэл зүй лабораторын судалгаагаар *93.3 хувь буюу 14 хүнд нь хамар, хоолой* залгиурын арчдасын шинжилгээнд, *14 хүний* цэрэнд, *86.6 хувь буюу 13 хүний өтгөнөөс авсан шинжилгээнд* Короновирус илэрсэн. Харин шинж тэмдэг балархай /бүдэг/ нэг хүний өтгөнөөс үүсгэгч илэрч, хамар залгиур, цэрнээс илрээгүй *(2020 оны 04 сарын 6)*.

Дурангийн тусламж үйлчилгээний халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлан ажилласнаар COVID-19вирусын тахал хумигдаж, тахлын муруй хавтгайрахад туслах, үйлчлүүлэгч ба бусад ажилчдад учирч болох эрсдэлийг бууруулах, ялангуяа ажилчид өвчилсний улмаас ажлаас чөлөө авах хувийг бууруулах ач холбогдолтой.

Үйлчлүүлэгчид ба ажилчдад шаардлагатай тусгай Хувь Хүнийг Хамгаалах хувцас хэрэгслийн нөөц хязгаарлагдмал байгаа учраас нөөцийг нэмэгдүүлэх, боломжит цөөн тоогоор ажиллах багийг төлөвлөх, шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгслийн (дурангийн зүү, уурга, гадны биет авагч, сорьц авах чимхүүр, эм бэлдмэл г.м) хангамж, бэлэн байдлыг шуурхай хангах шаардлагатай.

Дэлхий даяар тархсан цар тахалын үед эмнэлгийн дурангийн тасгийн ажилчид ба бүх ажилтнууд халдвараас сэргийлэх, өөрсдийгөө хамгаалах талаар хариуцлагатай байх хэрэгтэй.

COVID-19вирусын цар тахлын үед хоол боловсруулах дурангийн шинжилгээг хэрхэн хийх, шинжилгээний явцад баримтлах журам,

заавар батлагдаагүй байгаа тохиолдолд дараах ерөнхий стратегийн дагуу ажиллах нь зүйтэй: Зайлшгүй шаардлагатай бус тохиолдолд болон урьдчилан сэргийлэх үзлэгийн зорилгоор дурангийн шинжилгээг ХИЙХГҮЙ!

НЭГ. ЕРӨНХИЙ ЗААВАР

Дурангийн тасгаар үйлчлүүлэх бүх хүмүүст COVID-19-ийн халдварын эрсдэлийн үнэлгээг хийнэ. Процедурын өмнөх өдөр бүх үйлчлүүлэгчийг сувилагч дуудан 2020.02.21 НЭМГ-ын 1/156 тушаалын COVID-19 ийн түр зөвлөмжийн дагуу эрүүл мэндийн асуумжийг тодруулан үйлчлүүлэгчийн эрсдэлийг үнэлэх (Хавсралт 1. 2) ба дурангийн мэргэжлийн эмч тухайн тохиолдлын эрсдэлийн үнэлгээ, эрэмбэлэн ангилалт хийж (Хавсралт 3) шаардлагатай тохиолдолд процедурын хуваарийг дахин тогтоох хэрэгтэй.

- Тухайн тасгийн баг дурангийн яаралтай тусламж үйлчилгээг ярилцаж төлөвлөж шийднэ.
- Цаг үеийн байдал өдрөөс өдөрт өөрчлөгдөж байгаа учраас эмч, эмнэлгийн менежерүүд шинээр гарч буй удирдамж, заавар зөвлөгөөг тогтмол шалгаж, шинэчлэнэ.
- Дурангийн тасгийн ажилчдын хамгаалах хэрэгслийн хангамж ба тоног төхөөрөмжийн нөөцийг эмнэлгийн захиргаа бүрэн хангах шаардлагатай

1.1. Уян дурангийн шинжилгээний үед хийх эрсдэлийн үнэлгээ:

Хоол боловсруулах замын дурангийн шинжилгээ, ажилбар хийхдээолон улсын дурангийн нийгэмлэгээс гаргасан зөвлөмжийн дагуу дурангийн шинжилгээ, ажилбар хийх шаардлагатай эсэхийг үнэлж 3 бүлэг болгон эрэмблэн ангилна.

1. Дурангийн ажилбар хийлгэх нэн шаардлагатай тохиолдол
2. Дурангийн ажилбарыг хойшлуулж болохуйц тохиолдол
3. Дурангийн ажилбар хийх эсэхийг зөвлөлдөх шаардлагатай тохиолдол (боломжтой бол тохиолдол бүрийг зөвлөх эмчтэй хамтран ярилцах)

А. Дурангийн ажилбар хийлгэх нэн шаардлагатай тохиолдол

- Хоол боловсруулах замын цочмог цус алдалт
- Улаан хоолойн цочмог бөглөрөл – гадны биет, хоол хүнс, нарийсал (pinhole stricture)/ хавдарын улмаас стент тавих шаардлагатай.
- Цоорлын үед дурангийн тусламжтай хийгдэх вакуум эмчилгээ
- Цочмог холангит, хавдар, цөсний бөглөрлийн улмаас 2-догчоор шарлалт үүсэх
- Цөс, нойр булчирхайн хурц үрэвсэл, чулуу болон шарлалттай хавсарсан холангит
- Халдварын шалтгаант уутлагдсан үхжил (WON-walled of necrosis)
- Гадуур эмчлүүлэгчдэд яаралтай тэжээл эмчилгээ хийх – PEG/NJ tube
- Ходоод гэдэсний замын бөглөрлийн үед яаралтай хийгдэх стент/decompression

В. Дурангийн ажилбарыг хойшлуулж болохуйц тохиолдол:

- Хорт хавдарын сэжигтэй тохиолдлын лавлагаа, давтан үзлэг
- Төлөвлөгөөт POEM – peroral endoscopic myotomy, ахалазийн тэлэх (дилатаци) эмчилгээ
- Бусад сонголтот эмчилгээ: PEG, нарийсал тэлэх, RFA, GAVE үед хийгдэх APC, ампулэктоми
- Бариатрийн дурангийн ажилбарууд
- Бага эрсдэлтэй, давтан хийгдэх дурангийн шинжилгээ - улаан хоолойн үрэвслийн эдгэрэлт, ходоодны шархны эдгэрэлт, EMR, RFA полипэктомийн дараах хяналтын дуран.
- Ажиглалт: Ургацагийн хяналт, Гэдэсний үрэвсэлт эмгэг /IBD/, Барретын улаан хоолой.
- Өдөр тутмын яаралтай бус нарийн гэдэсний дуран шинжилгээ
- Хоргүй хавдрын заалтаар EUS хийх, цөсний тэлэгдэлт, чулуу байх магадлалтай, салстын доорх үүсгэвэр, эрсдэл бага нойр булчирхайн уйланхай.
- Зарим ERCP хийх тохиолдол: Холангит үгүйсгэгдсэн цөсний замын чулуутайүед стент тавигдсан, архаг панкреатитын үеийн эмчилгээ, металл стент авах, солих, ампулэктомийн хяналт
- Бүдүүн гэдэсний дурангийн шинжилгээг тухайн хүнтэй зөвлөлдөх хүртэл зогсооно. Үүнд тухайн ажилбарт оролцогч эмч, бусад ажилчдад тулгарч болох эрсдэл болон яаралтай тусламж үйлчилгээний бэлэн байдлыг бодолцож, тодорхой эрсдэлийн үнэлгээ хийх шаардлагатай.
- Эмнэлзүйн судалгааны хүрээнд дурангийн шинжилгээ хийлгэж, биопси эд өгч буй өвчтөнүүд зэрэг хамаарна.

С. Дурангийн ажилбар хийх эсэхийг зөвлөлдөх шаардлагатай (боломжтой бол тохиолдол бүрийг зөвлөх эмчтэй хамтран ярилцах)

Үйлчлүүлэгч бүрийн эрсдэлийг үнэлж, эрэмбэлэн ангилалтын лавлагааг баримтлана (Хүснэгт 1).

- 2 долоо хоногийн хугацаанд хүлээх боломжтой хавдар, бусад хавсарсан эмгэг
- Эмнэлгийн удирдлагатай ярилцаж зөвлөлдөх хүртэл бүдүүн гэдэсний скрийнинг шинжилгээг хийхгүй. Үүнд тухайн ажилбарт оролцох эмч, сувилагч бусад ажилчдад тулгарч болох эрсдэл болон яаралтай тусламж үйлчилгээний бэлэн байдлыг тооцон, тодорхой эрсдэлийн үнэлгээг хийж шийдвэр гаргах шаардлагатай.
- Ургацаг, EMR, ESD
- Шинээр сэжиглэгдэж буй бүдүүн гэдэсний цочмог үрэвсэл
- Хавдарын үе шатыг тодорхойлох EUS, эдийн шинжилгээ хийх эсэх

Хүснэгт 1. Үйлчлүүлэгчийн эрсдэлийн үнэлгээ

№	Дурангийн шинжилгээнд хамрагдаж буй өвчтөнүүдэд COVID-19халдварын эрсдэлийг ангилах	
1	Бага эрсдэл	Шинж тэмдэг байхгүй (жишээлбэл, ханиалгах, халуурах, амьсгал давчдах, суулгах гэх мэт) • COVID-19 эерэг хүнтэй ойрын хавьтал байхгүй • Өмнөх 14-28 хоногийн хугацаанд өндөр эрсдэлтэй бүсэд зорчоогүй байх
2	Дунд эрсдэлтэй	Шинж тэмдэг илэрсэн • COVID-19эерэг хүнтэй ойрын хавьтал үүсгэсэн эмнэлгийн түүх байхгүй • Өмнөх 14 хоногийн хугацаанд өндөр эрсдэлтэй бүсэд зорчоогүй байх Шинж тэмдэг байхгүй ч гэсэн • COVID-19 эерэг хүнтэй ойрын хавьталтай • Өмнөх 14-28 хоногийн хугацаанд өндөр эрсдэлтэй бүсэд зорчсон
3	Өндөр эрсдэлтэй	Дор хаяж нэг шинж тэмдэг илэрсэн + дараах хавьтлын аль нэг нь илэрсэн бол • COVID-19эерэг хүнтэй ойрын хавьталтай • Өмнөх 14 хоногийн хугацаанд өндөр эрсдэлтэй бүсэд зорчисон
*- Яаралтай тохиолдол, ба асуумжийг бүрэн аваагүй үед бүх процедурыг өндөр эрсдэлтэй гэж үнэлнэ.		

1.2. COVID-19 халдварын үед уян дурангийн шинжилгээнд хамрагдах үйлчлүүлэгчдэд эрсдэлийн үнэлгээг дараах хүснэгтийн дагуу эрэмбэлэн ангилна.

- Дурангийн тасгаар үйлчлүүлж байгаа өвчтөний асран хамгаалагч болон хамаатан садан нь өвчтөнд тодорхой туслалцаа, орчуулгын үйлчилгээ шаардахгүй бол дурангийн тасагт орохыг хатуу хориглоно.
- Энэ халдварт өвчний дэгдэлт бүрэн шийдэгдэх хүртэл дурангийн ажилбар хийлгэсэн өвчтөн шинж тэмдэг илэрвэл (жишээлбэл, ханиалгах, халуурах, амьсгал давчдах, суулгах гэх мэт) тус тасагт утсаар мэдэгдэнэ.


ХОЁР. ДУРАНГИЙН ТАСАГТ БАРИМТЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУР ЗААВАР

2.1. Дурангийн тасагт баримтлах халдвар хамгааллын дэглэм

Дурангийн тусламж үйлчилгээ үзүүлэх үед Дурангийн тасаг нэгжид халдвар хамгааллын заавар,дотоод үйл ажиллагааны зохион байгуулалт, дэг журмыг доорх схем дарааллын дагуу чанд мөрдөж үйлчлүүлэгчийг сонгохдооэрүүл мэндийн асуумж (Хавсралт 1), COVID-19 халдварын үед уян дурангийн шинжилгээнд хамрагдах үйлчлүүлэгчдийг эрэмбэлэн ангилах эрсдэлийн үнэлгээг (Хавсралт 2) мэргэжлийн сувилагч, тухайн тохиолдлын эрсдэлийнүнэлгээ, эрэмбэлэн ангилалтыг (Хавсралт 3) дурангийн мэргэжлийн эмч тус тус хийж өндөр хариуцлагатай ажиллахыг нөхцөл байдал шаардаж байна.

2.2. Үйлчлүүлэгчийн хувцаслалт, хэрэглэл

- Дурангийн тасгаар үйлчлүүлж байгаа үйлчлүүлэгч, эмчлүүлэгч болгон мэс заслын маск (surgical mask) зүүсэн байна. Хэрэв дунд ба өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн бол нэмэгдээд нэг удаагийн бээлий өмссөн байна.


Дурангийн тасагт эмнэлгийн ажилчид нэвтрэх заавар I
Хаалгаар орохын өмнө заавал халуунаа хэмжүүлнэ
Гараа халдваргүйжүүлнэ
Халдваргүйжүүлэлт хийсний дараа тасагт орно
Өөртөө байгаа гар утас түлхүүр чагнуур гэх мэт зүйлсээ Alcohol Pads-ээр халдваргүйжүүлнэ
Дурангийн тасагт баримтлах дэг
Эмч,сувилагч нар эмнэлгийн хувцасыг бүрэн гүйцэд өмсөнө
Маскаа 2 цаг тутамд солино
Нүүр, нүд, амандаа гараа хүргэхгүй байх
Өөрийн эд зүйлс болох бал, чагнуур гар утас/ дамжуулж хэрэглэхийг хориглоно
Эмч, сувилагч бүр халаасандаа 2 ширхэг балтай байх
Үйлчлүүлэгч дурангийн тасаг руу нэвтрэх заавар
Үйлчлүүлэгчийн халуун хэмжинэ. (сувилагч)
Асуумж авна. Хэрвээ амбулатороос асуумж авсан бол дахин асуумж
Асуумж аваад халуунтай тохиолдолд эмчид мэдэгдэнэ.
Асуумжийн дагуу сувилагч эрэмбэлэн ангилалт хийнэ.
Эргэлзээтэй тохиолдолд дуран хийх эмч мэдээллэнэ
Эмч ганцаар шийдвэр гаргах боломжгүй бол бусад эмч нартай зөвлөлдөнө
Сувилагчид хариу мэдэгдэнэ
Үйлчүүлэгчийг шинжилгээнд бэлтгэнэ
Дурангийн өрөөнд оруулна



Зураг 1. Дурангийн тасгийн сувилагч, эмчийн Хамгаалах ХувцасХэрэглэлийг хэрэглэх зааварчилгаа

- Дурангийн ажилбарын өмнө маскийг тайлна. Процедурын үед үйлчлүүлэгч ухаан алдах эсвэл тайвшруулгатай дурангийн шинжилгээ хийх шаардлага тулгардаг. Тайвшруулгатай дуран хийсний дараа үйлчлүүлэгчийг сэрээх өрөөнд хүчилтөрөгчийн хангамжийг >90% байлгахаар зохицуулж маскийг дахин зүүлгэнэ.

2.3. Дурангийн тасгийн ажилчдын урьдчилан сэргийлэх арга хэмжээ ба хувцаслалт

Эмнэлгийн бүх ажилчид дурангийн тасагт нэвтрэх тохиолдолд урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээг мөрдөн, өөрийгөө бэлтгэнэ. Дурангийн тасгийн бүх үйл ажиллагааны үед үйлчлүүлэгчээс аль болох зай барьж ажиллах ба үйлчлүүлэгчтэй харьцахын өмнө ба дараа, хамгаалах хэрэгслийг өмсөх, тайлсны дараа тохиолдол болгонд гарыг савантай усаар угаах эсвэл спиртэнд суурилсан гар халдваргүйжүүлэгчээр халдваргүйтгэнэ. Зураг 1-д үзүүлсэнчлэн дурангийн тасгийн сувилагч, эмчийн Хамгаалах Хувцас Хэрэглэлийг хэрэглэх зааварчилгааг үзүүлэв.

2.4. Дурангийн тасгийг А, В бүсд хуваах халдвар хамгааллын дэглэмийг баримтална (дуугүй хөтөчөөр зааглана)

А бүсэд: Дурангийн ажилбарын өрөө, Багаж ариутгалын өрөө

В бүсэд: Бэлтгэлийн өрөө, зөвлөгөө өгөх өрөө, хувцас солих өрөө, сэрээх өрөө, үйлчлүүлэгчийн хүлээлгийн хэсэг

- Дурангийн ажилчид А бүсэд дунд ба өндөр эрсдэлтэй тохиолдолтой ажиллахдаа малгай (толгойн алчуур), маск N95, нүдний шил, нэг удаагийн хамгаалах комбинзон, ус үл нэвтрэх хормогч, нүүрний халхавч, 2 давхар бээлий өмсөнө
- Дурангийн ажилчид А бүсэд бага эрсдэлтэй тохиолдолтой ажиллахдаа малгай (толгойн алчуур), мэс заслын маск, нэг удаагийн халад, нүүрний халхавч, 2 давхар бээлий өмсөнө
- Дурангийн ажилчид В бүсэд ажиллахдаа эмнэлгийн дүрэмт хувцас, малгай өмсч, мэс заслын маск зүүнэ
- Хамгаалах хувцас хэрэгсэл өмсөж, тайлахдаа ДЭМБ-с гаргасан зөвлөмжийн

дагуу зориулалтын хэсэгтгүйцэтгэнэ. ДЭМБ-с гаргасан зөвлөмжийг хувцас өмсөх, тайлах хэсэгт байрлуулж мөрдөж ажиллана.

2.5. COVID-19 дэгдэлтийн үеийн сөрөг даралттай өрөөний үүрэг

ASGE-гаас зөвлөснөөр дурангийн тасаг бүрд сөрөг даралт бүхий өрөө шаардлагатай. Хэрэв сөрөг даралттай өрөө байвал амьсгалын замын зовуурьтай бүх үйлчлүүлэгчийг тухайн өрөөнд хүлээж авахыг зөвлөдөг.

2.6. Дурангийн тасгийн халдваргүйжүүлэлт, ариутгалыг хийх заавар

ЭМС-ын А/537 тушаал, ДЭМБ-ын COVID-19 үеийн зөвлөмжийн дагуу халдваргүйжүүлж ариутгана.

Дурангийн тасгийн өрөө бүрийг цэвэрлэх хувааръ, халдваргүйжүүлэх бодисыг нэрлэсэн нарийн заавартай байх хэрэгтэй ба ажилбар бүрийн төгсгөлд цэвэрлэнэ. Цэвэрлэгээний үед аль болох бүх гадаргуугцэвэрлэх ба тоосонцор, биофилмийн зориулалтын халдваргүйжүүлэх бодисоор халдваргүйжүүлнэ. Короновирусийн гадаргууд амьдрах хугацааны талаарх мэдээллийг анхаарч COVID-19 үеийн халдваргүйжүүлэх бодисыг сонгон хэрэглэнэ. COVID-19 нь шээс, өтгөнд 1-2 өдөр амьдрах чадвартай учраас орчны гадаргууд мөн хугацаагаар амьдрах эрсдэлийг тооцно.

Ялангуяа үйлчлүүлэгчийн байнга хүрдэг орны орчим, даавуу болон тавилгыг өдөр бүр тогтмол нарийн цэвэрлэх хэрэгтэй. Бага эрсдэлтэй үйлчлүүлэгч үйлчлүүлсэн хавьталгүй өрөөнд ердийн журмаар цэвэрлэнэ. Сөрөг даралттай өрөөг үйлчлүүлэгч хүлээж авахаас өмнө багадаа өрөөг 30 минутаас 1 цаг хүлээлгэнэ.

2.7. Дурангийн багаж хэрэгсэл халдваргүйжүүлэлт, ариутгал хийх заавар

Дурангийн тоног төхөөрөмж, зарим хэрэгслийг ариутгаж дахин хэрэглэдэг учир ариутгал халдваргүйтгэлийн олон улсын удирдамж, ЭМС-ын А/537 тоот тушаал зааврыг баримталдаг. COVID-19 үед дурангийн багаж хэрэгслийг цэвэрлэх, халдваргүйжүүлж ариутгах ажлын дараалал, хэрэглэх бодисын талаар өөрчлөлт оруулсан байна. Иймд дурангийн ариутгал халдваргүйжүүлэх үйл ажиллагаанд онцгой анхаарч, шинэ заавар зөвлөмжийг мөрдөн ажиллахыг нөхцөл байдал шаардаж байна (Зураг 2).

ГУРАВ. ЕРӨНХИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ХАЛДВАРААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД ЗОРИУЛСАН ЗӨВЛӨМЖ

Аливаа процедурын үед тухайн өрөөнд байх эмч ажилчдын тоог хязгаарлах /резидентүүдийн тоог мөн хязгаарлах/

Дээр дурдсан дуран шинжилгээ болон ажилбаруудын тоог зөвлөх эмчтэйгээ ярилцаж аль болох бууруулах.

Өдөр бүр хэрэглэж буй тоног төхөөрөмж, хэрэгслийн нөөцийг тогтмол үнэлэнбэлэн байдлыг хангах, шаардлагагүй худалдан авалт хийхгүй байх. Ханган нийлүүлэгч байгууллагуудтай байнгын холбоотой ажиллах.

Бусад нэмэлт шаардлагатай багаж хэрэгслийг төлөвлөх.



Зураг 2. Дурангийн багаж хэрэгслийг цэвэрлэх, халдваргүйжүүлж ариутгах ажлын дараалал

Хавсралт 1

Хүснэгт 1

ЭРҮҮЛ МЭНДИЙН АСУУМЖ

2020.... сарын .....өдөр

1. Овог .....
2. Нэр .....
3. Хүйс Эр Эм /доогуур нь зурна уу/
4. Иргэншил .....
5. Регистр .....
6. Гэрийн хаяг.....
7. Утасны дугаар.....
8. Шаардлагатай үед холбоо барих хүний нэр, утасны дугаар .....
9. Сүүлийн 14-21 хоногт халдвар бүртгэгдсэн орнуудаар зорчсон эсэх
   Тийм Үгүй /доогуур нь зурна уу/
10. Тийм бол ямар орноор зорчсон .....
11. Сүүлийн 14-21 хоногт халдвар бүртгэгдсэн орнуудаар зорчсон хүнтэй хамт байсан эсэх
    Тийм Үгүй /доогуур нь зурна уу/
12. Танд дараах шинж тэмдэг илэрч байвал + тэмдэг тавина уу?

№	Илэрсэн шинж тэмдэг	+ -		Илэрсэн шинж тэмдэг	+ -
1	38^0 С-ээс дээш халуурах		8	Хэвлийгээр өвдөх	
2	Толгой өвдөх		9	Бөөлжих	
3	Булчингаар өвдөх		10	Суулгах	
4	Нүд улайх		11	Чичрэх	
5	Хоолой өвдөх		12	Арьсны тууралт	
6	Ханиалгах		13	Унтаа байдалд	
7	Хамраас нус гоожих		14	Бие сулрах	

АСУУМЖ АВСАН:

Албан тушаал ..... Овог, нэр ..... Гарын үсэг .....

Хавсралт 2

COVID-19 халдварынүед уян дурангийн шинжилгээнд хамрагдах ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙГ ЭРЭМБЭЛЭН АНГИЛАХ эрсдэлийн үнэлгээний хуудас

Үйлчлүүлэгчийн Овог:.....Нэр:.....

2020 оны..... сарын.....өдөр

(Хамааралтай бол:О, Хамааралгүй бол: Х – р тэмдэглэнэ) *2020.03.27 нд*

№	Дурангийн шинжилгээнд хамрагдаж буй өвчтөнүүдэд COVID-19 халдварын эрсдэлийг ангилах	Үнэлгээ
1	Бага эрсдэл	Шинж тэмдэг байхгүй (жишээлбэл, ханиалгах, халуурах, амьсгал давчдах, суулгах гэх мэт) • COVID-19 эерэг хүнтэй ойрын хавьтал байхгүй • Өмнөх 14-28 хоногийн хугацаанд өндөр эрсдэлтэй бүсэд зорчоогүй байх	
2	Дунд эрсдэлтэй	Шинж тэмдэг илэрсэн • COVID-19 эерэг хүнтэй ойрын хавьтал үүсгэсэн эмнэлгийн түүх байхгүй • Өмнөх 14 хоногийн хугацаанд өндөр эрсдэлтэй бүсэд зорчоогүй байх Шинж тэмдэг байхгүй ч гэсэн • COVID-19 эерэг хүнтэй ойрын хавьталтай • Өмнөх 14-28 хоногийн хугацаанд өндөр эрсдэлтэй бүсэд зорчисон	

3	Өндөр эрсдэлтэй	Дор хаяж нэг шинж тэмдэг илэрсэн + дараах хавьталын аль нэг нь илэрсэн бол • COVID-19 эерэг хүнтэй ойрын хавьталтай • Өмнөх 14 хоногийн хугацаанд өндөр эрсдэлтэй бүсэд зорчсон

*- Яаралтай тохиолдол, ба асуумжийг бүрэн аваагүй үед бүх процедурыг өндөр эрсдэлтэй гэж үзнэ.

Асуум авсан:

Албан тушаал ..... Овог, нэр ..... Гарын үсэг .....

Хавсралт 3

Дурангийн оношлогоо эмчилгээ хийх *ТОХИОЛДЛЫГ* эрэмбэлэн ангилах эрсдэлийн үнэлгээ

Үйлчлүүлэгчийн Овог:..... Нэр:.....

2020 оны..... сарын.....өдөр

(Хамааралтай бол: Хамааралгүй бол: Х – р тэмдэглэнэ)

Эрсдэлийн үнэлгээ	Нийгдэх процедурын нэрс	Үнэлгээ
А. Дурангийн ажилбар хийлгэх нэн шаардлагатай тохиолдол	Хоол боловсруулах замын цочмог цус алдалт	
	Улаан хоолойн цочмог бөглөрөл – гадны биет, хоол хүнс, нарийсал (pinhole stricture)/хавдарын улмаас стент тавих шаардлагатай.	
	Цоорлын үед дурангийн тусламжтай хийгдэх вакуум эмчилгээ	
	Цочмог холангит, хавдар, цөсний бөглөрлийн улмаас 2-догчоор шарлалт үүсэх	
	Цөс, нойр булчирхайн хурц үрэвсэл, чулуу болон шарлалттай хавсарсан холангит	
	Халдварын шалтгаант уутлагдсан үхжил (WON-walled of necrosis)	
	Гадуур эмчлүүлэгчдэд яаралтай тэжээл эмчилгээ хийх – PEG/NJ tube	
	Ходоод гэдэсний замын бөглөрлийн үед яаралтай хийгдэх стент/ decompression	
В. Дурангийн ажилбарыг хойшлуулж болохуйц тохиолдол:	Хорт хавдарын сэжигтэй тохиолдлын лавлагаа, давтан үзлэг	
	Төлөвлөгөөт POEM – peroral endoscopic myotomy, ахалазийн тэлэх (дилатаци) эмчилгээ	
	Бусад сонголтот эмчилгээ: PEG, нарийсал тэлэх, RFA, GAVE үед хийгдэх APC, ампулэктоми	
	Бариатрийн дурангийн ажилбарууд	
	Бага эрсдэлтэй, давтан хийгдэх дурангийн шинжилгээ – улаан хоолойн үрэвслийн эдгэрэлт, ходоодны шархны эдгэрэлт, EMR, RFA полипэктомийн дараах хяналтын дуран.	
	Ажиглалт: Ургацагийн хяналт, Гэдэсний үрэвсэлт эмгэг /IBD/, Барретын улаан хоолой.	
	Өдөр тутмын яаралтай бус нарийн гэдэсний дуран шинжилгээ	
	Хоргүй хавдрын заалтаар EUS хийх, цөсний тэлэгдэлт, чулуу байх магадлалтай, салстын доорх үүсгэвэр, эрсдэл бага нойр булчирхайн уйланхай	
	Зарим ERCP хийх тохиолдол: Холангит үгүйсгэгдсэн цөсний замын чулуутай үед стент тавигдсан, архаг панкреатитын үеийн эмчилгээ, металл стент авах, солих, ампулэктомийн хяналт	
	Бүдүүн гэдэсний дурангийн шинжилгээг тухайн хүнтэй зөвлөлдөх хүртэл зогсооно. Үүнд тухайн ажилбарт оролцогч эмч, бусад ажилчдад тулгарч болох эрсдэл болон яаралтай тусламж үйлчилгээний бэлэн байдлыг бодолцож, тодорхой эрсдэлийн үнэлгээ хийх шаардлагатай.	
	Эмнэлзүйн судалгааны хүрээнд дурангийн шинжилгээ хийлгэж, биопси эд өгч буй өвчтөнүүд зэрэг хамаарна.	

С. Дурангийн ажилбар хийх эсэхийг зөвлөлдөх шаардлагатай	2 долоо хоногийн хугацаанд хүлээх боломжтой хавдар, бусад хавсарсан эмгэг
	Бүдүүн гэдэсний скрийнинг шинжилгээг хийхгүй. Үүнд тухайн ажилбарт оролцох эмч, сувилагч бусад ажилчдад тулгарч болох эрсдэл болон яаралтай тусламж үйлчилгээний бэлэн байдлыг тооцон, тодорхой эрсдэлийн үнэлгээг хийж шийдвэр гаргах шаардлагатай.
	Ургацаг, EMR, ESD
	Шинээр сэжиглэгдэж буй бүдүүн гэдэсний цочмог үрэвсэл

Асуумж авсан:
Албан тушаал Овог, нэр Гарын үсэг

Temporary instructions for endoscopy unit during COVID-19 pandemic

Kh.Oyuntsetseg1,2, R.Namsrai1,2, M. Badrah1,2,3, O. Bayarsaikhan1,2.3, B. Gantuya1,2,3, D. Davaadorj1,2,3, A. Enkh Amar1,2,3, D. Soyolmaa1,2, Ch. Bayarnemekh1,2

[1]Mongolia-Japan Hospital of MNUMS
[2]Mongolian Society of Gastrointestinal Endoscopy
[3]MNUMS, School of Medicine, Department of Gastroenterology
oyuntsetseg.kh@mnums.edu.mn

Abstract

The temporary instruction for endoscopy unit during Covid-19 pandemic is intended for gastroenterologist, endoscopist, nurses, technician and gastroenterology fellows to prevent the risk of transmission during endoscopy, to maintain safety endoscopy and to educate employees about infection prevention. This temporal guideline was processed by the physicians and nurses of Mongolia-Japan Hospital and teachers of MNUMS, School of Medicine, and Department of Gastroenterology as well as Mongolian Society of Gastrointestinal Endoscopy.

НОМЗҮЙ:

1. Coronavirus (COVID-19) outbreak: what the department of endoscopy should know. Alessandro Repici1,2 , Roberta Maselli1 , Matteo Colombo1,2, Roberto Gabbiadini1,2 , Marco Spadaccini1,2 , Andrea Anderloni1 , Silvia Carrara1 , Alessandro Fugazza1 , Milena Di Leo1,2 , PieraAlessia Galtieri1 , Gaia Pellegatta1 , Elisa Chiara Ferrara1 , Elena Azzolini3 and Michele Lagioia3 1 Humanitas Clinical and Research Center, Digestive Endoscopy Unit, Division of Gastroenterology, Rozzano (Milan). 2 Humanitas University, Department of Biomedical Sciences, Rozzano (Milan). 3 Humanitas Clinical and Research Center, Clinical Quality Department, Rozzano (Milan)American Society for Gastrointestinal Endoscopy - ASGE [published online ahead of print, 2020 Mar 13]. GastrointestEndosc. 2020;S0016-5107(20)30245-5. doi:10.1016/j.gie.2020.03.01http://ow.ly/VQf750yLt77
2. Endoscopy activity and COVID-19: BSG and JAG guidance – update 22.03.20https://www.bsg.org.uk/COVID-19-advice/endoscopy-activity-and-COVID-19-bsg-and-jag-guidance/?fbclid=IwAR0i2NIE_oC2T1TLYzX4K8qyx8-YCuE3g5b99WfzYXBfuabwlqHbypZOM_Y
3. 2020.02.21 НЭМГ-ын 1/156 тушаалын COVID-19 ийн түр зөвлөмж
4. ХӨСУТ-ийн Яаралтай тусламжийн тасгийн эрхлэгч, клиникийн эмч Б.Батсүхийн нийтлэл
5. Gastrointestinal Endoscopy 2020, doi:https://doi.org/10.1016/j.gie.2020.03.019